

POLSKA I MONGOLIA

WSPÓLNE DZIEDZICTWO,

WSPÓLNE PERSPEKTYWY



Польш ба Монгол улс

Хамтын уламжлал,

хамтын хэтийн төлөв

СЛОВО ВСТЕПНЕ

ОРШИЛ

Mimo że w 2025 roku obchodzimy 75. rocznicę zawarcia stosunków dyplomatycznych między Polską a Mongolią, relacje między krajami, cechujące się wyjątkowością, sięgają dużo dalej niż 75 lat wstecz. Na przekór dzielącej nas odległości, nasze państwa łączy przyjaźń. Dzięki temu oprócz współpracy politycznej, gospodarczej i technicznej, dbamy także o wymianę kulturalną i społeczną. Często dzielimy także podobny los, który wynika z niełatwego położenia geopolitycznego.

Polacy i Mongołowie cenią wolność i są przywiązani do wartości demokratycznych, charakteryzuje nas także duma ze swoich obyczajów i tradycji. Szacunek do drugiego człowieka, otwartość i gościnność pozostają najważniejsze – stanowią wręcz fundament naszych kultur. Stąd Polacy i Mongołowie łatwo nawiązują kontakty i dobrze ze sobą współpracują.

Wymienione powyżej cechy skutkują postrzeganiem Polski jako „trzeciego sąsiada” Mongolii. Mongołowie za to są w oczach Polaków zarówno spadkobiercami wielkiego Czyngis-chana, jak i po prostu przyjaznymi ludźmi. Mimo wielu różnic udzielamy sobie wsparcia jako państwa, narody, ale przede wszystkim – ludzie. W dziejach mogliśmy obserwować wiele osób, które przyczyniły się do rozwoju współpracy na różnych polach oraz, co najistotniejsze – do wzajemnego poznania kultury, historii i zwyczajów obu narodów. Ich praca, pasja i zaangażowanie odgrywają niezwykle ważną rolę w umacnianiu łączących nas więzi.

Owe relacje międzyludzkie kształtują pozostałe sfery współpracy. Polacy i Mongołowie są sobie bliscy, a bezpośrednie kontakty umacniają partnerstwo na płaszczyźnie politycznej, gospodarczej, społecznej i kulturalnej.

To właśnie o ludziach, budujących tradycyjne przyjazne relacje między Polską i Mongolią, jest ta wystawa.

Энэ онд Польш, Монгол Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэж байгаа боловч бидний найрсаг харилцаа үүнээс хамаагүй урт хугацаанд хөгжсөөр ирсэн билээ. Газар зүйн байршлаар алслагдсан манай хоёр улс, ард түмнийг найрсаг харилцаа нэгтгэн холбодог юм. Эл хэлхээ холбооны ачаар бид улс төр, эдийн засаг, техникийн хамтын ажиллагаа болон боловсрол, соёл, нийгмийн солилцоог хөгжүүлэн бэхжүүлсээр байна. Аль алиных нь геополитикийн эгзэгтэй байршлын улмаас Польш, Монгол хоёр ижил төстэй хувь заяаг туулж иржээ.

Польш, Монголын ард түмэн эрх чөлөөг дээдэлж, ардчилсан үнэт зүйлсийг хүндэтгэдэг. Бид өөрсдийн ёс заншил, уламжлалаараа бахархдаг. Бусдад хүндэтгэлтэй хандах, нээлттэй байдал, зочломтгой зан чанар нь бидний соёлын үндэс суурийг бүрдүүлдэг. Тиймээс Польш, Монгол хүмүүс хоорондоо амархан ойлголцон үр бүтээлтэйгээр хамтран ажиллаж чаддаг билээ.

Монгол Улс Польшийг "гурав дахь хөрш"-өө гэж үзэхэд эдгээр ижил төстэй онцлог шинж чанарууд ч зохих хэмжээнд нөлөөлдөг бизээ. Польшуудын хувьд монголчуудыг Чингис хааны өв залгамжлагчид гэж үзэхээс гадна энгийн найрсаг нэгэн ард түмэн хэмээн хүндэтгэн хүлээн авдаг. Улс орон, үндэстний хувьд ялгаатай талууд байх нь мэдээж хэдий ч бид харилцан нэгэндээ дэмжлэг үзүүлж хамгийн гол нь хувь хүн хооронд бие биендээ туслаж явдаг билээ. Түүхийн туршид олон хүн хоёр улсын харилцааг хөгжүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулсан байна. Тэдний хичээл зүтгэл, эрмэлзэл, оролцоо нь манай хоёр улс хоорондын нөхөрлөлийг улам бүр бэхжүүлж иржээ.

Хүн хоорондын харилцаа нь хамтын ажиллагааны салбар болгонд эергээр нөлөөлж байдаг юм. Польшууд болон монголчууд хоорондын харилцаа нь улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын түншлэлийг бэхжүүлж, хоёр улсын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд эерэгээр нөлөөлж байна.

Энэ үзэсгэлэн нь Польш, Монгол хоёр улсын хоорондох уламжлалт, найрсаг харилцааг бэхжүүлэн хөгжүүлсэн хүмүүсийн тухай түүхийг өгүүлэх болно.

PIERWSZE KONTAKTY АНХНЫ ХАРИЛЦАА

Pierwsze kontakty Polaków i Mongołów miały miejsce w XIII wieku i nie były ani przyjazne, ani pokojowe. W styczniu 1241 roku celem osłony głównego uderzenia wojsk mongolskich na Królestwo Węgier, część sił chana najechała ziemie polskie. Po spłądrowaniu Sandomierszczyzny i Małopolski, wojska mongolskie skierowały się na Śląsk.

9 kwietnia 1241 roku doszło do decydującej bitwy pod Legnicą, w której klęskę poniosły wojska polskie dowodzone przez Henryka Pobożnego. W drugiej połowie XIII wieku dwukrotnie jeszcze doszło do mongolskich najazdów.

W konsekwencji pojawienia się Mongołów – nie tylko w Polsce, lecz także w Europie – podjęte zostały wczesne próby nawiązania stosunków dyplomatycznych, w czym Polacy mieli swój udział. W 1245 roku papież Innocenty IV, pragnąc poznać Mongołów i zawrzeć z nimi kontakty, wysłał cztery poselstwa. Tylko jedno, pod przewodnictwem Giovanniego da Pian del Carpine, któremu towarzyszył polski franciszkanin, Benedykt Polak, dotarło latem 1246 roku do letniej siedziby chana Gajuka w okolicach stolicy imperium – Karakorum. Benedykt Polak, który prawdopodobnie znał język mongolski, zawarł w swoim sprawozdaniu tłumaczenie listu chana do papieża.

Od misji Giovanniego da Pian del Carpine i Benedykta Polaka do kolejnych oficjalnych kontaktów i relacji między naszymi narodami i państwami upłynęło wiele wieków, ale w tym czasie byli Polacy, których los rzucił do Mongolii




Bitwa pod Legnicą [w:] Vita beatae Hedvigis, 1353, J. Paul Getty Museum, Ms. Ludwig XI 7, fol. 11v.
1241 оны Легницийн тулалдаан, Гэгээн Хедвигийн домгоос сэдэвлэсэн зураг, 1353 он, Ж. Паул Геттын музей.

Польш, Монголын ард түмний анхны харилцаа XIII зуунаас эхэлсэн бөгөөд тэдгээр харилцаа нь найрсаг ч биш, эв найрамдалтай ч биш байсан. 1241 оны 1-р сард Унгарын вант улсруу дайрах Их Монгол улсын цэргийн гол хүчний баруун жигүүрийг халлах зорилгоор цэргийн нэг хэсэг нь Польшид довтлон орж Сандамиж болон Бага Польш мужийг эзэлсний дараа Силез рүү чиглэсэн.

Легницийн дэргэд болсон 1241 оны 4-р сарын 9-ний шийдвэрлэх тулалдаанд II Хенрик Побожны Вангийн удирдсан Польшийн цэргийн хүч ялагдсан. XIII зууны сүүлийн хагаст Монголчууд Польшийн нутагруу хоёр удаа дахин довтолжээ.

Монголчууд Польшид төдийгүй Европт анх удаа гарч ирсний дараа Европчууд нь дипломат харилцаа тогтоох эхний оролдлого хийцгээсэн. Үүнд Польшууд бас хувь нэмрээ оруулсан ажээ. Ромын Пап лам IV Инноцент 1245 онд Монголчуудын талаар мэдээлэл авч, харилцаа холбоо тогтоохоор Монголын эзэнт гүрэнлүү дөрвөн элчийг илгээсэн байна. Тэдний дундаас зөвхөн элч нарын ахлагч Жованни да Пиан дел Карпини болон түүнтэй хамт явсан Польшийн санваартан франциска II Бенедикт Полак 1246 оны зун Гүюг хааны зуны өргөө болох Монголын эзэнт гүрний нийслэл Хархорум орчимд хүрчээ. II Бенедикт Полакм монгол хэл мэддэг байсан байж магадгүй. Тэрээр аяллын талаарх тэмдэглэлдээ Пап ламд илгээсэн Гүюг хааны захидлыг орчуулан бичиж өгчээ.

Жованни да Пиан дель Карпине, II Бенедикт Полак нарын айлчлалаас хойш манай хоёр улсын ард түмэний хооронд албан ёсны харилцаа тогтоосноос хойш олон зуун жил өнгөрсөн. Энэ хугацаанд Польшууд Монголд өнөөдрийг хүртэл аялаж байна.



Pomnik upamiętniający XIII-wieczną misję dyplomatyczną Benedykta Polaka, Karakorum, Ambasada RP.
XIII зуунд Монголын эзэнт гүрний нийслэл Хархорумд хүрэлцэн ирсэн Бенедикт Полакад зориулсан дурсгалын хөшөө, Хархорум хот, БНПУ-ын Элчин сайдын яамны архив.

RELACJE DYPLOMATYCZNE - РОСЧАТКИ ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ ЭХЛЭЛ

Początek XX wieku przyniósł niepodległość zarówno Polsce, jak i Mongolii. Polska była jednym z pierwszych państw europejskich, które uznały niepodległość Mongolii i nawiązały stosunki dyplomatyczne z tym krajem. Odbyło się to za pośrednictwem ambasadorów w ZSRR, N. Jadamdżawa (MRL) i Mariana Naszkowskiego (PRL) 14 kwietnia 1950 roku.

Pierwsze lata stosunków dyplomatycznych ograniczały się jedynie do wizyt wysoko postawionych przedstawicieli rządowych. Wszystko zmieniło się wraz z podpisaniem umów handlowych pod koniec lat 50. i otwarciem placówek dyplomatycznych w obu krajach na początku lat 60. Pod koniec lat 80. relacje łączące Polskę i Mongolię zaczęły się rozluźniać, co doprowadziło do zamknięcia polskiej ambasady w Ułan Bator w 1995 roku. Mongolska ambasada w Warszawie działa nieprzerwanie.





Wizyta Ju. Cedenbała, Przewodniczącego Rady Ministrów MRL w Polsce, 1957 r., Mongolskie Archiwum Państwowe.
БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ю. Цэдэнбалын БНПАУ-д хийсэн айлчлал, 1957 он, МУ-ын Архивын ерөнхий газар.



W. Jaruzelski i Dz. Batmonch podczas wizyty w Mongolii, 1987 r., Archiwum prywatne Dz. Altangerel.
Ерөнхийлөгч В. Ярузельскийн БНМАУ-д хийсэн айлчлал, Ж. Батмөнхийн хамт, 1987 он, Ж. Алтангэрэлийн хувийн архив.

XX зууны эхээр Польш, Монгол хоёр улс тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан билээ. Польш нь Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоосон Европын анхны улсуудын нэг байлаа. 1950 оны 4-р сарын 14-нд Москва дахь БНМАУ-ын Элчин сайд Н.Ядамжав, БНПАУ-ын Элчин сайд М.Нашковски нар ноот бичиг солилцсоноор хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтжээ.

Хоёр улсын Дипломат харилцаа нь эхний жилүүдэд зөвхөн өндөр, дээд түвшний албан тушаалтнуудын айлчлалаар хязгаарлагдаж байв. 50-иад оны сүүлчээр худалдааны гэрээ байгуулж, 60-аад оны эхээр хоёр улсад дипломат төлөөлөгчийн газар харилцан нээгдсэнээр харилцаанд ихээхэн өөрчлөлт гарсан юм. Польш, Монголын харилцаа 80-аад оны сүүлчээс суларч эхэлсний улмаас 1995 онд Улаанбаатар дахь Польшийн Элчин сайдын яам хаагдсан. Харин Варшав дахь Монголын Элчин сайдын яам тасралтгүй ажилласаар өнөөдрийг хүрсэн билээ.




Noty dyplomatyczne ws. zawarcia stosunków dyplomatycznych między PRL i MRL, 1950 r., Archiwum MSZ.
БНПАУ, БНМАУ-ын хооронд дипломат харилцаа тогтоох тухай дипломат ноот бичиг, 1950 он, ГХЯ-ны архив архив.

WSPÓŁCZESNE RELACJE DYPLOMATYCZNE ОРЧИН ҮЕИЙН ДИПЛОМАТ ХАРИЛЦАА

Pod koniec tysiąclecia, 9 grudnia 1999 roku, prezydent Mongolii N. Bagabandi złożył w Polsce oficjalną wizytę państwową, która miała przynieść rozwój relacji w wielu aspektach. Inne wydarzenia, na przykład ponowne otwarcie Ambasady RP w Ułan Bator w 2000 roku czy wizyta prezydenta Lecha Kaczyńskiego w 2008 roku, zdawały się także przynosić tego rodzaju nadzieje. Jednakże po zaledwie dziewięciu latach działalność polską placówkę zamknięto ponownie. Mimo tej decyzji, w kolejnych latach rozwijała się współpraca w sferze stosunków politycznych. W 2013 roku odbyły się wizyty prezydentów – C. Elbegdordża w Polsce i Bronisława Komorowskiego w Mongolii, a później ministrów wielu resortów z obu krajów.


W 2023 roku prezydent Andrzej Duda złożył w Mongolii wizytę, w trakcie której otworzył nową siedzibę reaktywowanej w 2021 roku polskiej ambasady w Ułan Bator. Natomiast w jubileuszowym 2025 roku do Polski przyjechał Prezydent Mongolii U. Churelsuch. Podpisano wówczas deklarację o wszechstronnym partnerstwie.




Wizyta Prezydenta L. Kaczyńskiego w Mongolii, 2008 r., KPRP.
Ерөнхийлөгч Л. Качиньскийн Монгол Улсад хийсэн айлчлал, 2008 он, БНПУ-ын ЕТГ.



Wizyta Prezydenta C. Elbegdordża w Polsce, 2013 r., KPRP.
Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийн БНПУ-д хийсэн айлчлал, 2013 он, БНПУ-ын ЕТГ.



Uroczystość ponownego otwarcia Ambasady RP w Ułan Bator, 2023 r., KPRP.
Улаанбаатар дахь БНПУ-ын Элчин сайдын яамыг сэргээн нээх ёслолын арга хэмжээ, 2023 он, БНПУ-ын ЕТГ.



Podpisanie Deklaracji o wszechstronnym partnerstwie. Wizyta Prezydenta U. Churelsucha w Polsce, 2025 r., KPRP.
Ерөнхийлөгч У. Хүрэлсүхийн БНПУ-д хийсэн айлчлал, 2025, Иж бүрэн түншлэлийн хамтарсан тунхаглалд гарын үсэг зурах ёслол, БНПУ-ын ЕТГ.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1999 оны 12-р сарын 9-нд Польшид төрийн айлчлал хийв. Айлчлал хоёр улсын хооронд олон талт харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилготой байлаа. Польшийн Элчин сайдын яамыг 2000 онд Улаанбаатар хотод дахин нээж, 2008 онд Ерөнхийлөгч Лех Качиньски Монголд айлчлал хийснээр хамтын ажиллагаа идэвхжих хүлээлт бий болоод байлаа. Гэвч ердөө 9 жилийн дараа Польшийн дипломат төлөөлөгчийн газар дахин хаагдсан юм. Харин энэ хугацаанд хоёр улсын төрийн хамтын ажиллагаа тасалдалгүй үргэлжлэн хөгжсөөр байв. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 онд Польш Улсад, Польш Улсын Ерөнхийлөгч Б.Коморовски Монгол Улсад тус тус айлчилсаны дараа хоёр улсын холбогдох яамдын сайд нарын түвшний харилцан айлчлал олон удаа болжээ.

Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дудагийн 2023 онд Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр 2021 онд дахин нээгдсэн Польшийн Элчин сайдын яам шинэ байрандаа нүүж орсон юм. Хоёр тал дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойг тэмдэглэж буй 2025 онд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Польш Улсад айлчилж Иж бүрэн түншлэлийн хамтарсан тунхаглалд гарын үсэг зурлаа.

WSPÓŁPRACA W OKRESIE SOCJALIZMU

СОЦИАЛИЗМЫН ҮЕД ХАМТЫН АЖИЛЛАГАА

Lata 1950-1990 we wzajemnych relacjach upłynęły pod znakiem międzynarodowej przyjaźni opartej na założeniach komunistycznych. Przedstawiciele Polski i Mongolii kilkakrotnie odbywali oficjalne wizyty na najwyższym szczeblu. W tym czasie rozkwitła współpraca polityczna, gospodarcza, techniczna, kulturalna i naukowa.

Wzajemne kontakty nabrały szczególnego znaczenia na początku lat sześćdziesiątych, kiedy zawarto pierwszą umowę dotyczącą realizacji wspólnych celów gospodarczych (1961) oraz kiedy Mongolia przystąpiła do Rady Wzajemnej Pomocy Gospodarczej (1962). Mongolia mogła liczyć na wsparcie głównie w budownictwie, przemyśle drzewnym, wydobywczym, spożywczym oraz w rolnictwie. Dzięki umowom kredytowym Polska zrealizowała w Mongolii ważne projekty infrastrukturalne, takie jak fabryka cegieł i wapna w Darchanie i Czobjalsan, zakład przetwórstwa drewna i fabryka betonu lekkiego w Ułan Bator oraz elektrociepłownia i zakład przetwórstwa odpadów odzwierzęcych w Charchorin.



Delegacja przedstawicieli władz PRL z wizytą w mongolskiej fabryce cegieł, lata 60. XX w., Mongolskie Archiwum Państwowe.
БНПАУ-ын төр засгийн төлөөлөгчид Монголын тоосгоны үйлдвэрт зочлов, 1960-аад он, МУ-ын Архивын Ерөнхий Газар.



Wizyta polskiej delegacji w ulanbatorskim zakładzie przetwórstwa drewna. Lata 70. XX w., Mongolskie Archiwum Państwowe.
Польшийн төлөөлөгчид Улаанбаатар дахь мод боловсруулах үйлдвэрт зочлов, 1970-аад он, МУ-ын Архивын Ерөнхий Газар.



Wizyta przedstawicieli biura CEKOP w wybudowanej przez Polaków fabryce w Mongolii, lata 70. XX w., Archiwum prywatne O. Uziembło.
CEKOP (Бүрэн тоноглогдсон үйлдвэрийн байгууламж-экспортлох төв байгууллага)-ын төлөөлөгчид Польшийн тусламжаар барьсан мод боловсруулах үйлдвэрт зочлов, 1970-аад он, О. Узембло хувийн архив.



„Pierwsza” cegła w wybudowanej przez Polaków mongolskiej fabryce cegieł. Lata 60. XX w. Archiwum prywatne Dż. Altangerel.
Польшийн тусламжаар Монгол Улсад барьсан тоосгоны үйлдвэрийн “анхны” тоосго, 1960-аад он, Ж. Алтангэрэлийн хувийн архив.

Польш, Монгол хоёр орны 1950-1990 оны харилцаа нь коммунист үзэл баримтлалд үндэслэсэн нөхөрлөлийн хүрээнд өрнөсөн юм. Энэ хугацаанд Польш, Монгол Улсын хооронд дээд хэмжээний албан ёсны айлчлал хэд хэдэн удаа болж, улс төр, эдийн засаг, техник, соёл, шинжлэх ухааны хамтын ажиллагаа ихээхэн өргөжин хөгжжээ.

Хоёр талын хамтарсан эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэх анхны гэрээ 1961 онд байгуулагдаж, 1962 онд Монгол Улс Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлд (ЭЗХТЗ) элсэв. 1960-аад оноос хоёр тал хоорондын харилцаа, хамтын ажиллагаандаа онцгой ач холбогдол өгч иржээ. Монгол Улс мод боловсруулах үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэл, барилга, уул уурхай, хөдөө аж ахуйн салбарт голлон Польш Улсаас тусламж дэмжлэг авч байв. Польштой байгуулсан зээлийн гэрээний дагуу Дархан, Чойбалсанд тоосгоны үйлдвэр, шохойн үйлдвэр, Улаанбаатарт мод боловсруулах үйлдвэр, хөнгөн бетоны үйлдвэр, Хархоринд дулааны цахилгаан станц болон малын гаралтай хаягдал боловсруулах үйлдвэр зэрэг чухал ач холбогдолтой төслүүд хэрэгжүүлсэн байна.

WSPÓŁPRACA W OKRESIE SOCJALIZMU

СОЦИАЛИЗМЫН ҮЕД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Projekt dzielnicy mieszkaniowej w Ulan Bator autorstwa polskich architektów, 1964 r., „Architektura” 11/1965.
Польский архитекторыдын боловсруулсан Улаанбаатар хотын орон сууцны хорооллын зураг төсөл, 1964 он, 11/1965 Архитектура сэтгүүл.

Obok współpracy gospodarczej czy eksportu polskich maszyn i technologii do Mongolii od 1961 roku dynamicznie rozwijała się również współpraca naukowo-techniczna, polegająca na wymianie specjalistów i studentów. Zespoły polskich architektów, pod mongolskim kierownictwem, realizowały w Ulan Bator w latach sześćdziesiątych m.in. projekty zabudowy osiedli. Natomiast w Polsce szkoliły się mongolskie kadry techniczne i naukowe, które potem rozwijały działalność wspólnych przedsiębiorstw i projektów infrastrukturalnych stworzonych z polską pomocą w Mongolii.

Polsko-mongolska współpraca w okresie socjalizmu szacowana jest na kilkadziesiąt milionów rubli transferowych pożyczek i bezzwrotnej pomocy.



Polski motocykl SFM Junak w mongolskim stepie, „Nowa Wies” 17 (750), 1963 rok. Archiwum Stowarzyszenia Miłośników i Posiadaczy Motocykla Junak SFM.
Польский СФМ Юнак маркийн мотоцикл Монголын тал нутагт, „Nowa Wies” 17 (750) сэтгүүл, 1963 он. СФМ Юнак маркийн мотоцикл эзэнууд ба сонирхогчдийн нийгэмлэг.

Эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд польшийн машин, техник технологийг Монголд экспортлохоос гадна 1961 оноос эхлэн шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагаа идэвхтэй өрнөж, мэргэжилтэн, оюутны солилцоо эхэлжээ. Польшийн архитекторууд монголчуудын удирдлага дор Улаанбаатар хотын орон сууцны хорооллын төлөвлөлтийн төслүүдийг 1960-аад оноос хэрэгжүүлжээ. Харин Польш Улсад суралцсан монголын шинжлэх ухаан, техникийн мэргэжилтнүүд Польшийн тусламжаар байгуулсан үйлдвэр, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Социализмын үеийн Польш-Монголын хамтын ажиллагааны хүрээнд олгосон буцалтгүй зээл, тусламж нь хэдэн арван сая шилжих рубльд хүрчээ.



Микробус Nysa 501 на улцах Улан-Батор, кадр з филму „Өндөр ээж” з 1968 року.
Польскийн 501 Ныса маркийн микробус Улаанбаатар хотын гудамжаар. 1968 оын “Өндөр ээж” киноны зураг.



Wizyta polskiej delegacji w ulanbatorskim zakładzie przetwórstwa drewna. Lata 70. XX w., Mongolskie Archiwum Państwowe.
Польскийн төлөөлөгчдийн Улаанбаатар мод боловсруулах үйлдвэрт зочиллоо. 1970-аад он, МУ-ын Архивын Ерөнхий Газар.

EKSPORT DEMOKRACJI АРДЧИЛЛЫН ЭКСПОРТ

Wydarzenia polityczne w Polsce od 1989 roku i transformacja ustrojowa dokonana przy udziale NZSS „Solidarność” stały się inspiracją dla społeczeństw Europy Środkowej i Wschodniej, ale nie tylko. Wiatr zmian w tej części świata dotarł także na mongolski step.

Tamtejsi młodzi demokraci mieli za czasów studenckich kontakty z polskimi zwolennikami demokracji i obficie korzystali z tego doświadczenia. Naturalne było wzorowanie się na działalności „Solidarności”, która także bezpośrednio pomagała mongolskim demokratom. Znak NZSS „Solidarność” pojawił się na plakatach i ulotkach wyborczych, służąc za symbol walki o wolność.

Demokratyzacja Mongolii następowała szybko i pokojowo, o czym mogli zaświadczyć Polacy obecni przy tym procesie. Maciej Jankowski był jednym z międzynarodowych obserwatorów podczas pierwszych wielopartyjnych wyborów w Mongolii.



Plakaty z logo Solidarności na ulicach Ulan Bator w 1990 roku.
Эв санааны нэгдэл “Солидарность” хөдөлгөөний тэмдэг бүхий ухуулах хуудас Улаанбаатар хотын гудамжнаа, 1990 он.



Obserwatorzy wyborów w 1990 roku odwiedzają klasztor Gandan. Po prawej Maciej Jankowski, archiwum prywatne C. Karwowski.
1990 оны сонгуулийн ажиглагчид (баруун талд нь Мачией Янковски) Гандантэгчинлэн хийдэд зочлов, Ц.Карвовскийн хувийн архив.



Projekt i oryginalny plakat z kampanii wyborczej 1990 r., archiwum prywatne J. Rogala.
1990 оны сонгуулийн сурталчилгааны загвар ба эх зурагт хуудас. Я.Рогалагийн хувийн архив.

“Эв санааны нэгдэл” (“Солидарность”) хөдөлгөөний тэмцлийн үр дүнд Польшид хийгдсэн улс төрийн системийн өөрчлөлт нь Зүүн болон Төв Европын улс орнуудад 1980-аад оны сүүлчээр хүчтэй нөлөөлжээ. Шинэ үеийн салхи Европоос Монголын тал нутагт ч хүрч өөрчлөлт авчирсан билээ.

Монголын залуу ардчилагчдын өөрчлөлтийн төлөөх тэмцэлд оюутан ахуйдаа Польшийн ардчилсан хүчнийхэнтэй тогтоосон харилцаа холбооны үрээр олж авсан туршлага, мэдлэг ихээхэн тус дэмжлэг болжээ. “Эв санааны нэгдэл”-ийн зүтгэлнүүд Монголын ардчилсан хүчинд шууд туслаж байсан юм. Монголчууд “Эв санааны нэгдэл” хөдөлгөөний үйл ажиллагааг жишиг болгон ажиллаж байсан. “Эв санааны нэгдэл”-ийн тэмдэг нь Монголын сонгуулийн сурталчилгааны уриа, ухуулах хуудсан дээр хэвлэгдэж, эрх чөлөөний тэмцлийн билэг тэмдэг болжээ.

Монголын ардчилал тайван замаар хурдтай өрнөсөн. Энэ үйл явцыг ажиглаж байсан польшууд үүнийг батлаж чадна. М.Янковски 1990 оны Монголын анхны олон намын сонгуулийн олон улсын ажиглагчдын нэг нь байсан юм.



Druk ulotek wyborczych w mieście Chowd, 1992 rok., Archiwum prywatne M. Kmicik.
Сонгуулийн сурталчилгааны материал хэвлэх үйл явц, Ховд хот, 1992 он, М.Кмичикийн хувийн архив.

ЕКСПОРТ ДЕМОКРАСЈИ АРДЧИЛЛЫН ЭКСПОРТ



Przyjazd szkoleniowców z Solidarności do Ułan Bator, w tle wózek bagażowy m.in. z plakatami i powielaczami, 1992 r., archiwum prywatne M. Kmicik.

Эв санааны нэгдлийн сургагч багш нар Улаанбаатар хотод хүрэлцэн ирэв (ухуулах хуудас хэвлэх, хувилах машин зэрэг ачаа тээшээ зөөж буй байдал), 1992 он, М.Кмицикийн хувийн архив.

Wsparcie ideologiczne i materialne ze strony polskich demokratów nabrało wielkiego znaczenia wraz z rozpoczęciem prac nad nową konstytucją Mongolii. Jednym z Polaków zaangażowanych w jej powstanie był Piotr Winczorek, wybitny konstytucjonalista z Uniwersytetu Warszawskiego.

Wraz z uchwaleniem ustawy zasadniczej rozpisano w 1992 roku nowe wybory w Mongolii. Wówczas ponownie doświadczeni działacze „Solidarności” udzielili mongolskim przyjacielom pomocy. Miała ona charakter szkoleniowy, materialny i logistyczny. Materiały wyborcze powstawały na przywiezionych z Polski powielaczach i sitach drukarskich.

Mongołowie docenili wkład polskich kolegów w demokrację, nagradzając ich wysokimi odznaczeniami państwowymi. Wielu bohaterów tamtych wydarzeń pełniło później ważne stanowiska polityczne. Za przykłady posłużyć mogą Bogdan Borusewicz, marszałek Senatu (2005-2015) i A. Ganbaatar, ambasador Mongolii w Polsce (2012-2016).



Wizyta Przewodniczącego Wielkiego Churału Mongolii, Dz. Enchbolda w Europejskim Centrum Solidarności w Gdańsku, 2015 r. Po prawej Ambasador A. Ganbaatar, po lewej Marszałek Senatu RP, B. Borusewicz, wieloletni przyjaciele. Archiwum prywatne J. Rogala.

Монгол Улсын Их Хурлын дарга З.Энхболд Европын эв санааны нэгдлийн төвд зочлов, Гданьск хот, 2015 он (баруун талд Элчин сайд А.Ганбаатар, зүүн талд БНПУ-ын Сенатын маршал Б.Борусевич, тэд эртний андууд). Я.Рогалагийн хувийн архив.

Монголын шинэ Үндсэн хууль боловсруулах ажил эхлэх үеэр Польшийн ардчилсан хүчний үзэл суртлын болон материаллаг дэмжлэг нь онцгой ач холбогдолтой болжээ. Монголын ардчилсан шинэ Үндсэн хуулийг боловсруулахад Польшийн нэрт эрдэмтэн, Үндсэн хууль судлаач, Варшавын Их Сургуулийн профессор П.Винчорек оролцсон байна.

Монголын шинэ Үндсэн хуулийг баталсны дараа 1992 онд сонгууль явагдсан бөгөөд Польшийн Эв санааны нэгдлийн туршлагатай гишүүд дахин Монголын ардчилсан хүчнийг дэмжиж сургалт явуулж эд материалын болон логистикийн тусламж үзүүлжээ. Польшоос нийлүүлсэн хэвлэлийн тоног төхөөрөмжөөр Монголын сонгуулийн материалуудыг хэвлэж байв.

Монголчууд ардчилалд хувь нэмэр оруулсан Польшийн андуудаа өндрөөр үнэлж тэдэнд төрийн дээд шагнал олгосон юм. Хожим нь эдгээр үйл явдалд гар бие оролцогсдын ихэнх нь улс төрийн өндөр албан тушаал хашиж байжээ. Тухайлбал, Б.Борусевич Польшийн Сенатын даргаар, (2005-2015), А.Ганбаатар Монгол Улсаас Бүгд Найрамдах Польш Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдаар (2012-2016) ажиллаж байсан.



Plakat wyborczy "Oddajmy swoje głosy na demokrację", 1990 r., archiwum prywatne J. Rogala. "Ардчиллын төлөө саналаа өгцгөөе" уриатай сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал, 1990 он, Я.Рогалагийн хувийн архив.

OBECNA WSPÓŁPRACA GOSPODARCZA

ОДООГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Od 1990 roku relacje między Polską a Mongolią w zakresie gospodarki dynamicznie się rozwijały. W latach 90. intensyfikowano wymianę handlową, a Polska stała się jednym z kluczowych partnerów Mongolii w Europie. Obok aktywnych kontaktów w sferze publicznej ważną rolę zaczęły odgrywać inicjatywy prywatne.

Pionierami polskich inwestycji w demokratycznej Mongolii stały się dwie firmy: Bracia Urbanek w sektorze spożywczym i Horus-Energia w sektorze technicznym. Z inicjatywy ambasadora T. Baasansurena i polskich przedsiębiorców w 2003 roku utworzona została Polsko-Mongolska Izba Gospodarcza, której działalność obecnie kontynuuje powołana w 2013 roku Polsko-Mongolska Izba Przemysłowo-Handlowa. W ciągu ostatnich pięciu lat obroty handlowe wzrosły dwukrotnie (do 100 milionów dolarów), a polskie produkty nieprzerwanie cieszą się w Mongolii dobrą opinią.



J. Koblak i B. Bjambadordż – partnerzy biznesowi przed siedzibą firmy Monhorus w Ulan Bator. Archiwum prywatne J. Koblak.
Я.Коблак, Б.Бямбадорж нар бизнесийн түншүүд Улаанбаатар дахь Монхорус компанийн төв байрны өмнө. Я. Коблакийн хувийн архив.



Kolejny agregat z Sulejówka rozpoczyna prace w Mongolii. Z lewej B. Bjambadordż, w środku J. Koblak. Archiwum prywatne J. Koblak.
Судэювэк хотод үйлдвэрлэсэн дизель генератор Монголд ажиллаж эхлэв (Зүүн гар талд Б.Бямбадорж, голд нь Я.Коблак), Я.Коблакийн хувийн архив.



B. Lchagwadżaw i K. Urbanek. Od 30 lat dodają smaku mongolskim potrawom. 2024 r. Андууд, бизнесийн түнш болох Б.Лхагважав, К.Урбанек, тэд 30 гаруй жил монгол хоолны амтыг илүү амтлаг болгосоор байна, 2024 он.



Produkty Braci Urbanek na każdym mongolskim świątecznym stole. Bracia Urbanek-ийн бүтээгдэхүүн монгол айл бүрийн баярын ширээн дээр.

Польш, Монголын эдийн засгийн харилцаа 1990 оноос хойш эрчимтэй хөгжсөөр байна. Польш Улс Европ дахь Монголын гол түншүүдийн нэг болж худалдааны харилцаагаа хөгжүүлж ирлээ. Олон нийтийн салбарт идэвхтэй харилцаа өрнөхийн зэрэгцээ хувийн санаачлагууд мөн чухал үүрэг гүйцэтгэж байна.

Ардчилсан Монгол Улсад Польшийн хөрөнгө оруулалтын анхдагчид нь хүнсний салбарт "Bracia Urbanek", техникийн салбарт "Horus-Energia" компаниуд байлаа. Элчин сайд Т.Баасансүрэн болон Польшийн бизнес эрхлэгчдийн санаачилгаар 2003 онд Польш-Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим байгуулагдсан бөгөөд 2013 оноос Польш-Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулсаар байна. Сүүлийн таван жилийн хугацаанд хоёр улсын худалдааны эргэлт хоёр дахин нэмэгдэж 100 сая ам. долларт хүрлээ. Польшийн бүтээгдэхүүн Монголд өндөр үнэлгээтэй байна.

ОБЕСНА WSPÓŁPRACA GOSPODARCZA ОДООГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Dowodem na rozwój wielosektorowej współpracy jest udzielony Mongolii w 2017 roku polski kredyt w formie pomocy wiązanej, w ramach którego 50 milionów euro zostało przeznaczone na finansowanie projektów związanych z modernizacją rolnictwa, infrastruktury, edukacji, ochrony środowiska oraz ochrony zdrowia.

Ostatnie wizyty na najwyższym szczeblu i zorganizowane w ich trakcie fora biznesowe świadczą o możliwościach wielotorowego rozwoju dotychczasowych relacji i kontaktów.




Ambulanse i wozy strażackie dostarczone w ramach rządowej umowy kredytowej między Polską a Mongolią na wystawie w Ulan Bator, 2024 r.
Бүгд Найрамдах Польш Улс, Монгол Улсын Засгийн газрын хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн төслийн хүрээнд нийлүүлсэн түргэн тусламж болон гал унтраах машин Улаанбаатарт хүргэгдэв, 2024 он.

Польш Улсаас 2017 онд олгосон 50 сая еврогийн нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд хөдөө аж ахуй, дэд бүтэц, боловсрол, байгаль орчин, эрүүл мэндийн салбарт шинэчлэл хийх төслүүдийг санхүүжүүлж байгаа.

Сүүлийн үед хоёр улсын ерөнхийлөгчийн хийсэн айлчлал, айлчлалын хүрээнд зохион байгуулсан бизнес форум өнөөгийн харилцаа, холбоог нэлээдгүй салбарт өргөжүүлэх боломжтойг харуулж байна.



Prezydenci Polski i Mongolii podczas Polsko-Mongolskiego Forum Biznesowego w Ulan Bator, 2023 r., KPRP.
Улаанбаатар хотноо зохион байгуулсан Польш-Монголын бизнес форумын үеэр Польш, Монгол хоёр улсын Ерөнхийлөгч нар уулзсан. 2023 он, БНПУ-ын ЕТГ.



Polska aktywnie wspiera inicjatywy społeczne na rzecz osób z niepełnosprawnościami w Mongolii.
Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг Польш идэвхтэй дэмжсээр ирсэн.



Kolejne 35 nowoczesnych ambulansów z Polski przekazane Ministerstwu Zdrowia Mongolii, 2024 r.
Иж бүрэн тоноглогдсон 35 түргэн тусламжийн машиныг Монгол Улсын Эрүүл мэндийн яаманд хүлээлгэн өгөв, 2024 он.



Kawiarnia prowadzona przez osoby z zespołem Downa w Ulan Bator. Powstała ona dzięki polskiemu wsparciu.
Улаанбаатар хотод Монголын Дауны Холбооны хөдөлмөр сургалтын төв болон кофе шопыг БНПУ-ын ГХЯ-ны "Хөгжлийн хөтөлбөр"-ийн санхүүжилтээр байгуулав.



Wizyta Pierwszej Damy RP A. Kornhauser-Dudy we wspieranym przez „polską pomoc” przedszkolu prowadzonym przez Caritas Mongolia, 2023 r., KPRP.
Польш Улсын Тэргүүн хагатай А. Корнхаузер-Дуда БНПУ-ын ГХЯ-ны "Хөгжлийн хөтөлбөр"-ийн хүрээнд хамтран ажилладаг Каритас Монголиа байгууллагын харьяа хүүхдийн цэцэрлэгт зочлов, 2023 он, БНПУ-ын ЕТГ.


WSPÓŁPRACA NAUKOWA

ШИНЖЛЭХ УХААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА

W roku 1962 zawarto pierwsze polsko-mongolskie umowy o współpracy naukowej, co poskutkowało organizacją w latach 1963-1971 ośmiu ekspedycji naukowych pod przewodnictwem Zofii Kielan-Jaworowskiej. Badacze skierowali się na pustynię Gobi, gdzie odkryto cenne skamieniałości dinozaurów, ich jaj, a także późniejszych ssaków, pochodzące przede wszystkim z okresu kredy oraz paleogenu i neogenu. Część tych znalezisk można dziś obejrzeć na wystawie Muzeum Ewolucji w Warszawie.

Polscy geolodzy już w latach 1961-1966 prowadzili swoje prace poszukiwawcze pod kierownictwem Edmunda Rutkowskiego. Następnie stali się członkami Międzynarodowej Ekspedycji Geologicznej w Mongolii (1976-1990).

Odbyły się też liczne ekspedycje etnograficzne pod kierownictwem Witolda Dynowskiego.



Polska ekspedycja naukowa przy pracy. Odkryty szkielet tarbozaura, 1963-1971 r. Fotografie z książki Z. Kielan-Jaworowskiej *Polowanie na dinozaury* (1969).

Польский археологический экспедиц Монголын говьд судалгааны ажил хийх явцдаа Трабозаврын араг яс олсон байна, 1963-1971 он, З.Келан-Яворовскагийн "Үлэг гүрвэлийн ан агнуур" номын гэрэл зургууд (1969).

Польш, Монгол Улсын хооронд 1962 онд анх Шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны гэрээ байгуулагджээ. З.Киелан-Яворовскагийн удирдсан найман судалгааны экспедиц 1963-1971 онд Монголд ажилласан байна. Судлаачид Говьд үлэг гүрвэлийн чулуужсан яс, өндөгний малталт хийжээ. Мөн цэрдийн галавын болон палеоген, неогений үеийн хожим хөгжсөн хөхтөн амьтдын үлдэгдлийг илрүүлжээ. Эдгээр олдворын нэг хэсгийг Варшав дахь Эволюцийн музейд үзэж болно. Э.Рутковскийн удирдлага дор 1961-1966 онуудад польшийн геологичид Монголд хайгуулын ажил хийжээ. Польш Улс 1976-1990 онд Монгол дахь Олон улсын геологийн экспедицийн гишүүн орны нэг байсан юм.

Мөн Польш Улсын эрдэмтэн Профессор В.Диновскигийн удирдлага дор этнографийн экспедиц олон удаа Монголд ажиллаж байлаа.




Polska ekspedycja naukowa przy pracy. Fotografia z książki W. Dynowskiego *Współczesna Mongolia* (1968).

Польский шинжлэх ухааны экспедиц ажиллаж байна. В. Диновскигийн "Орчин үеийн Монгол улс" номын гэрэл зураг (1968).



Polscy geolodzy badają mongolską Gobi. Lata 80. XX w. Archiwum prywatne A. Bareja-Starzyńska. Польский геологичид Монголын говьд судалгаа шинжилгээний ажил явуулж байна, 1980-аад он, А.Барей-Стажинскагийн хувийн архив.



Polsko-mongolska ekspedycja paleontologiczna. Fotografia z książki Z. Kielan-Jaworowskiej *Polowanie na dinozaury* (1969).

Польш-Монголын хамтарсан палеонтологийн экспедиц. З.Келан-Яворовскагийн "Үлэг гүрвэлийн агнуур" номын гэрэл зургууд (1969).

WSPÓŁPRACA NAUKOWA

ШИНЖЛЭХ УХААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА



Polsko-Mongolska Ekspedycja Archeologiczna poszukuje śladów prehistorycznych społeczności na Gobi, 2024 r.

Польш-Монголын хамтарсан археологийн экспедици Монголын говиос эртний хүмүүсийн ул мөрийг хайж байна, 2024 он.

Po lekkim zastoju w latach 90. na początku XXI wieku nastąpił renesans kontaktów naukowych. W 2004 roku podpisano protokół o współpracy między instytucjami naukowymi obu państw. Obecnie organizowane są wyprawy geologiczne poszukujące surowców naturalnych, a także archeologiczne w celu odkrywania wczesnej aktywności gatunków człowieka na terenie obecnej Mongolii.

W ostatnich latach tempa nabiera również bezpośrednia współpraca między polskimi i mongolskimi uczelniami – prowadzone są na przykład wymiany studenckie. Dzięki nim do Polski przyjechało wielu mongolskich studentów, zainteresowanych przede wszystkim naukami ścisłymi. Z polskiej strony w Mongolii kształcą się głównie studenci mongolistyki i tybetologii Uniwersytetu Warszawskiego, którzy w ten sposób szlifują swoje umiejętności językowe oraz poznają bliżej mongolską kulturę.

90-ээд онд идэвх буурч зогсонги байдалд орсон боловч XXI зууны эхээр шинжлэх ухааны харилцаа дахин сэргэж эхэллээ. 2004 онд хоёр улсын шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааны Протоколд гарын үсэг зурсан байна.

Монголд одоогийн байдлаар геологийн экспедиц, нэн эртний түүх археологийн судалгааны экспедиц ажиллаж байна.

Сүүлийн жилүүдэд Польш, Монголын их, дээд сургуулиудын шууд хамтын ажиллагаа эрчимжиж, оюутны солилцоо идэвхтэй явагдаж байна. Үүний үр дүнд олон монгол оюутан Польшид байгалийн шинжлэх ухааны чиглэлээр суралцах болжээ. Польшийн талаас Варшавын Их Сургуулийн Монгол болон Төвд судлалын оюутнууд голдуу Монголд суралцаж хэлний чадвараа дээшлүүлэн монголын соёлыг илүү гүнзгий таньж мэдэн судлаж байна.



Polscy naukowcy wspierają rozwój mongolskiego rolnictwa dzieląc się swoim doświadczeniem i badaniami, 2022 r.

Польшийн эрдэмтэн судлаачид өөрсдийн туршлагаасаа хуваалцах замаар Монголын хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжин ажиллаж байна, 2022 он.



Podpisanie Porozumienia o Współpracy pomiędzy Polskim Towarzystwem Geologicznym a Mongolskim Towarzystwem Geologicznym. Początek nowej współpracy – 2025 r.

Польшийн Геологийн Холбоо, Монголын Геологийн Холбоо хооронд хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав. Энэ нь шинэ хамтын ажиллагааны эхлэл юм, 2025 он.



Podpisanie umowy o współpracy między Śląskim Uniwersytem Medycznym a Mongolską Akademią Medyczną. Współpraca w ochronie zdrowia jest jednym z kluczowych sektorów wzajemnej współpracy 2023 r.

Шлонскийн Анагаах ухааны их сургууль, Монголын Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль хооронд хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурав. Хоёр талын харилцааны чухал хэсэг бол эрүүл мэндийн салбарын хамтын ажиллагаа, 2023 он.

POLSCY MONGOLIŚCI

ПОЛЬШИЙН МОНГОЛ СУДЛААЧИД

Polscy badacze i badaczki mają duże zasługi w poznawaniu Mongolii i upowszechnianiu wiedzy o niej. Niektórzy z nich związali swoją pracę naukową z tym krajem na długo przed nawiązaniem oficjalnych relacji dyplomatycznych między Mongolią a Polską, bowiem tradycje polskiej mongolistyki sięgają czasów, kiedy państwa te pozostawały pod obcą kontrolą i nie było ich na mapach.

Jednym z pierwszych mongolistów na świecie był Józef Kowalewski (1801-1878), twórca szkoły studiów mongolistycznych w Kazaniu, a później wykładowca Uniwersytetu Warszawskiego. W carskiej Rosji Mongolię oraz jej mieszkańców badał również Władysław Kotwicz (1872-1944). Innymi wybitnymi naukowcami reprezentującymi mongolistykę są między innymi Marian Lewicki (1908-1955), Stanisław Kałużyński (1925-2006), Stanisław Godziński (1939-2024) i Jerzy Tulisow.





Uczestnicy wyprawy naukowej do Mongolii w 1912 roku. W środku siedzi prof. Władysław Kotwicz. Archiwum PAU i PAN w Krakowie.
1912 онд Монголд хийсэн шинжлэх ухааны экспедицийн оролцогчид. Голд профессор В. Котвич сууж байна. Краков дахь Польшийн Ур Чадварын Академи, ШУА-ийн архив.



Mongolowie docenili pracę i badania nad Mongolią prof. S. Kałużyńskiego. W 2006 roku otrzymał tytuł *doctor honoris causa* Państwowego Uniwersytetu Mongolskiego. Archiwum prywatne J. Rogala.
Профессор С.Калужинскийн Монгол судлал, эрдэм шинжилгээний ажлыг монголчууд өндөрөөр үнэлдэг. Тэрээр 2006 онд МУИС-ийн хүндэт докторын цол хүртсэн. Я.Рогалагийн хувийн архив.



Prof. S. Godziński, mongolista i były ambasador Polski w Mongolii, w 2008 roku został odznaczony Orderem Kubilaj-chana Mongolskiej Akademii Nauk. Archiwum prywatne J. Rogala.
Монгол судлаач, Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд асан проф. С.Годзиньски 2008 онд Монгол Улсын ШУА-ийн Хубилай хааны одонгоор шагнагджээ. Я.Рогалагийн хувийн архив.



Publikacje polskich mongolistów. Po prawej tłumaczenie Tajnej Historii Mongołów, po lewej opis mongolskiej gramatyki.
Польшийн монголч эрдэмтдийн бүтээл. (Баруун талд "Монголын нууц товчоо" польш орчуулга, зүүн талд Монгол хэлний дүрмийн тайлбар толь).

Польшийн эрдэмтэд Монгол судлал, Монголын талаарх мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан билээ. Монгол, Польш улсын хооронд дипломат харилцаа тогтоохоос өмнө зарим судлаачид эрдэм шинжилгээний ажлаа Монголтой холбосон байдаг. Манай хоёр улс гаднын эрхшээлд орж, дэлхийн газрын зургаас алга болсон үеэс эхлэн Польшид Монгол судлалын уламжлал тогтон хөгжиж ирсэн байна.

Дэлхийн анхны монгол судлаачийн нэг нь Ю.Ковалевски (1801-1878) юм. Тэрээр Казань хотод монгол судлалын сургалтын төв байгуулж, хожим нь Варшавын Их Сургуульд багшилж байжээ. Оросын эзэнт гүрний үед Монгол, монголчуудын талаар судалж байсан бас нэгэн нэрт эрдэмтэн бол В.Котвич (1872-1944) юм. Монгол судлалын чиглэлээр ажиллаж байсан нэр хүндтэй эрдэмтдээс М.Левицки (1908-1955), С. Калужиньски (1925-2006), С. Годзиньски (1939-2024), Е.Тулисов нарыг дурсч болно.

POLSCY MONGOLIŚCI

ПОЛЬШИЙН МОНГОЛ СУДЛААЧИД

S. Kałużyński, S. Godziński i J. Tulisow są związani z historią polskiej mongolistyki jako nauki akademickiej, której unikatowy w skali kraju program istnieje od lat 50. XX wieku na Uniwersytecie Warszawskim.

Obecnie we wspomnianym ośrodku akademickim działają Agata Bareja-Starzyńska, Jan Rogala, Magdalena Szpindler oraz Bjambaa Ragczaa, którzy rozwijają badania i przyczyniają się do utrwalenia relacji między Polską i Mongolią.



J. Tulisow wśród mongolskich Catanów—hodowców reniferów, 1968 r., archiwum prywatne J. Tulisow.
E. Тулисов монгол Цаатнуудын дунд, 1968 он. E. Тулисовын хувийн архив.





Polscy mongoliści mają wsparcie mongolskich władz. Prezydent Mongolii C. Elbegdordż i kierownik mongolistyki i tybetologii Uniwersytetu Warszawskiego, A. Bareja-Starzyńska w czasie wizyty prezydenta Mongolii w Polsce, 2013 r.
Монгол Улс Польшийн монголч эрдэмтдийг дэмжсээр ирсэн. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2013 онд БНПУ-д айлчлахдаа Варшавын Их Сургуулийн Монгол, Төвд судлалын тэнхимийн эрхлэгч, профессор А.Барей-Стажинскатай уулзав.

С.Калужиньски, С. Годзиньски, Е. Тулисов нарын гурван эрдэмтэн XX зууны 50-иад оноос Польш Улсын хэмжээнд өвөрмөц сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн нь Варшавын Их сургуулийн Монгол судлалын тэнхимийн түүхтэй холбоотой.

Одоо Варшавын Их сургуулийн Монгол судлалын тэнхимд А.Барей-Стажиньска, Я.Рогала, М.Шпиндлер болон Р.Бямбаа зэрэг судлаачид ажиллаж Монгол судлалын чиглэлээр ажиллах боловсон хүчин судлаачдыг бэлтгэх, Польш дахь Монгол судлал, хоёр орны хоорондын харилцааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



Obecni studenci, doktoranci i pracownicy naukowi mongolistyki i tybetologii UW często przyjmują wyjątkowych gości z Mongolii. Wizyta J.E. D. Dżawdzandordża—Chamba Lamy Klasztoru Gandantegczenlin w Ułan Bator, jednocześnie najwyższy hierarcha kościoła buddyjskiego w Mongolii, 2025 r.
Варшавын Их Сургуулийн Монгол Төвд судлалын тэнхимийн оюутан, докторант, эрдэмтэн багш нар Монголоос хүрэлцэн ирсэн хүндэтгэж зочдыг халуун дотноор хүлээн авдаг, Монголын Бурханы шашинтны төв Гандантэгчэнлин хийдийн Тэргүүн их хамба лам Д.Жавзандорж 2025 он БНПУ-д айлчлав.



Publikacje polskich mongolistów. Od prawej: pierwsze tłumaczenie na język angielski biografii Dzanabadzara, pierwszego mongolskiego Dżecundampy—religijnego i politycznego przywódcy Mongolów w XVII wieku, pierwszy polski podręcznik do nauki języka mongolskiego, opis pisma kwadratowego, stworzonego przez Dzanabadzara.
Польшийн монголч эрдэмтдийн бүтээл. (баруун талд XVII-р зууны Монгол улсын төр-нийгэм, шашин-соёлын нэрт зүтгэлтэн, анхдугаар Богд Жавзандамба хутагт Өндөр гэгээн Занабазарын намтарын анхны англи хэлний орчуулга; зүүн талд Занабазарын бүтээсэн дөрвөлжин үсгийн тайлбар; голд нь Польшид хэвлэсэн монгол хэлний анхны сурах бичиг).

MONGOLSCY POLONOFILE

МОНГОЛЫН ПОЛЬШ СУДЛААЧИД БА НАЙЗУУД



Pierwsza grupa mongolskich studentów w Polsce przed dawnym budynkiem Ambasady Mongolii przy Al. Ujazdowskich 12 w Warszawie. Lata 60. XX w. Archiwum prywatne Dz. Altangerel.
Польшид суралцахаар ирсэн анхны монгол оюутнууд Варшав дахь Монгол Улсын Элчин сайдын яамны хуучин байрны урд талд, Ал. Уяздовские тудамж 12, 1960-аад он, Ж.Алтангэрэлийн хувийн архив.

Historia studiów nad Polską rozpoczęła się w Mongolii w latach 50. XX wieku. Do lat 90. na studia polonistyczne były realizowane na Państwowym Uniwersytecie Mongolskim (МУИС) w ramach Centrum Języków Obcych, a obecnie w Zakładzie Slawistyki. Od początku program nauczania był ukierunkowany na przygotowanie studentów do zawodu tłumacza. Do grona znanych i zasłużonych absolwentów należała Dz. Altangerel, nauczycielka akademicka, tłumaczka i dyplomatk.

Obok absolwentów polonistyki Państwowego Uniwersytetu Mongolskiego grono mongolskich przyjaciół Polski stanowią absolwenci polskich uczelni. Dziś jest to kilkaset osób, które rozwijają i umacniają polsko-mongolską przyjaźń i stosunki. Są wśród nich naukowcy, żołnierze, biznesmeni czy politycy. Ważną rolę w umacnianiu relacji między naszymi krajami pełni społeczność lekarzy mongolskiej medycyny tradycyjnej, prowadzących swoją praktykę w Polsce od wielu lat. Jest to żywy przykład wzajemnego zaufania i przyjaźni Mongolii i Polski.



Członkowie Mongolsko-Polskiego Towarzystwa Przyjaźni to głównie absolwenci polskich uczelni. Archiwum prywatne B. Purewdo.
Монгол-Польшийн найрамдлын нийгэмлэгийн гишүүдийн ихэнх нь Польшийн их дээд сургуулийн төгсөгчид байдаг. Б.Пүрэвдоогийн хувийн архив.



Dz. Altangerel i ambasador Z. Kulak z pierwszą grupą mongolskich absolwentów polonistyki Państwowego Uniwersytetu Mongolskiego, 2008 r.
Проф. Ж.Алтангэрэл, БНПУ-ын Элчин сайд З.Кулак нар Монгол Улсын Их Сургуулийн Слав судлалын тэнхимийн польш хэлний ангийн анхны төгсөгчдийн хамт, 2008 он.

Монголд Польшийн талаарх судалгаа 1950-иад онд эхэлсэн. Монгол Улсын Их сургуулийн Гадаад хэлний сургалтын төвд Польш судлалын хөтөлбөр 1990-ээд он хүртэл хэрэгжиж байжээ. Өнөөдөр Слав судлалын тэнхимд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа. Анхнаасаа сургалтын хөтөлбөр нь оюутнуудыг орчуулагчийн мэргэжилд бэлтгэх чиглэлтэй байсан. Нэр хүндтэй төгсөгчдийн нэг нь багш, орчуулагч, гавьяат дипломатч Ж.Алтангэрэл байлаа.

Монгол дахь Польшийн анд нөхдийн бүлэгт Монгол Улсын Их сургуулийн Польш судлалын төгсөгчдөөс гадна Польшийн их, дээд сургуулийн монгол төгсөгчид ордог. Өнөөдөр хэдэн зууд хүрсэн тэдний дунд эрдэмтэн, цэргийн албан хаагч, бизнесмен, улстөрчид олон бий. Польшийн анд нөхөд Польш-Монголын харилцаа нөхөрлөлийг бататган хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна.

Польшид ажиллаж амьдарч байгаа Монголын уламжлалт анагаах ухааны эмч нар манай хоёр орны харилцааг бэхжүүлэхэд олон жилийн турш чухал үүрэг гүйцэтгэж ирснийг онцлон дурдах хэрэгтэй. Энэ нь Польш, Монголын харилцаан дахь итгэлцэл, нөхөрлөлийн бодит илэрхийлэл юм.



Mongolscy lekarze nie tylko leczą, ale też promują swoją kulturę wśród Polaków, 2022 r.
Монгол эмч нар Польшид эмчилгээ хийхээс гадна Монголын соёл, урлагийг сурталчилдаг, 2022 он.

KONTAKTY KULTURALNE СОЁЛЫН ХАРИЛЦАА

Współpracę kulturalną zapoczątkowano w końcu lat 50. XX w. Powołano wówczas do życia wzajemne towarzystwa przyjaźni. W 1984 roku odbyły się pierwsze Dni Kultury Polskiej w Mongolii, natomiast Dni Kultury Mongolskiej w Polsce zostały zorganizowane dwa lata później.

Po przemianach demokratycznych inicjatywę promocji kultury przejęły osoby indywidualne oraz organizacje pozarządowe. W 2000 roku powstało Towarzystwo Polska-Mongolia, którego pomysłodawcami byli m.in. Agata Bareja-Starzyńska oraz Jan Rogala. Kilka lat później zadania Towarzystwa przejęło Stowarzyszenie Polska-Mongolia powołane przez Grzegorza Cessaka.

Jedną z pierwszych inicjatyw Towarzystwa była organizacja w 2003 roku mongolskiego Naadamu – festiwalu, którego tradycje sięgają czasów Czyngis-chana. Podczas tego święta, trwającego trzy dni (10-13 lipca), Mongołowie spotykają się, aby współzawodniczyć w trzech dyscyplinach – łucznictwie, jeździe konnej oraz zapasach – a także brać udział w koncertach i innych wydarzeniach towarzyszących.

Obecnie dzięki współpracy Polaków i Mongołów oraz przy wsparciu Ambasady Mongolii Naadam odbywa się w Polsce co roku, zazwyczaj w podwarszawskim Powsinie. W trakcie tego wydarzenia Polacy mogą poznać mongolską kulturę i posmakować tradycyjnych potraw. Można wówczas zobaczyć mongolskie stroje, a także wziąć udział w niektórych aktywnościach. Oprócz zapasów niezwykle interesującym, a stałym już elementem powsińskiego Naadamu są zawody w strzelaniu specjalnymi kośćmi, szagajami, do celu.



Mongolskie Naadamy integrują Polaków i Mongołów. Archiwum prywatne J. Rogala.
Польшид зохион байгуулагддаг Монгол Наадам нь польш, монгол иргэдийг нэгтгэдэг, Я.Рогалын хувийн архив.



Mongolskie Naadamy organizowane w Polsce od ponad 20 lat przybliżają Polakom kulturę i obyczaje mongolskich przyjaciół. Archiwum prywatne J. Rogala.
Польш улсад 20 гаруй жил зохион байгуулагдаж буй Монгол Наадам нь польшуудад монгол анд нөхдийнхөө соёл, ёс заншилтай танилцах боломжийг олгосоор ирсэн, Я.Рогалын хувийн архив.

Польш, Монгол Улсын соёлын хамтын ажиллагаа ХХ зууны 50-иад оны сүүлчээр эхэлжээ. Энэ үеэр хоёр улсад Найрамдлын нийгэмлэг байгуулагдав. Польшийн соёлын өдрүүдийг 1984 онд анх Монгол улсад зохион байгуулав. Хоёр жилийн дараа Монголын соёлын өдрүүдийг Польшид зохион байгуулжээ.

Ардчилал өөрчлөлтийн дараач Монголын соёлыг Польшид таниулж, түгээн сурталчлах ажлыг хувь хүмүүс, төрийн бус байгууллагууд гүйцэтгэж ирсэн. А.Барей-Стажиньска, Я.Рогала нарын санаачилгаар 2000 онд Польш-Монголын нийгэмлэг байгуулагдлаа. Хэдэн жилийн дараа Г.Цессакийн үүсгэн байгуулсан Польш-Монголын холбоо тус Нийгэмлэгийн үүргийг өөртөө шилжүүлэн авчээ.

Польш-Монголын Холбоо нь 2003 онд Чингис хааны үеэс уламжлан ирсэн Эрийн гурван Наадмыг Варшав хотод амжилттай зохион байгуулав. Өдгөө монголчууд 7 сарын 10-13-ны өдрүүдэд морь уралдуулан бөх барилдуулж мөн сур харвуулан Эрийн гурван Наадмаа зохион байгуулсаар байдаг юм. Наадмаар бас урлаг, соёлын арга хэмжээ болдог.

Польш дахь Монголын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр монголчуудын Наадмыг Варшавын Повшин соёлын парсад жил бүрийн 6-р сард зохион байгуулдаг.

Энэ үеэр польш хүмүүс Монголын соёлыг танин мэдэж, уламжлалт хоол, ундаа амсах боломжтой. Мөн Монгол үндэсний хувцас үзэж, зарим арга хэмжээнд оролцох боломжтой байдаг. Бөхийн барилдаанаас гадна шагайн харваа олны сонирхолыг их татдаг юм. Польшид Монголын түүх, соёл урлагийн бүтээлүүдийг хэд хэдэн газарт үзэж болно.

KONTAKTY KULTURALNE СОЁЛЫН ХАРИЛЦАА

Sztukę mongolską w Polsce można obejrzeć w kilku miejscach, jednak do najważniejszych instytucji eksponujących dziedzictwo artystyczne i kulturowe tego kraju należą Muzeum Azji i Pacyfiku w Warszawie oraz Muzeum Mongolii w Budzie Ruskiej. W przypadku tego pierwszego Mongolii poświęcona jest sala na wystawie stałej *Podróże na Wschód*, drugie natomiast jest całkowicie przeznaczone na ekspozycję mongolskiej kultury wizualnej.

W Mongolii kultura polska również jest doceniana i popularyzowana, o czym świadczy fakt, iż w Ułan Bator organizowane są Międzynarodowe Konkursy Chopinowskie czy Dni Kina Polskiego. W 2024 odbyła się już trzynasta edycja pokazów polskiego kina – podczas niej zobaczyć można było takie filmy, jak *Twój Vincent* czy *Katedra*.



P. Malczewski, twórca Muzeum Mongolii prezentuje eksponaty. Archiwum prywatne P. Malczewski.
Монголын музейг санаачлагч П.Мальчевски музейн үзмэрүүдээ талцуулж байна. П. Малчевскийн хувийн архив.



Mongolska jurta na wystawie stałej w Muzeum Azji i Pacyfiku w Warszawie. MAiP.
Варшав хотын Ази, Номхон далайн музейн байнгын үзэсгэлэнд Монгол гэр тавигдсан байна. АНДМ.

Польскийн кино өдөр

2024
11/19-22
11:00

СУИС-ИЙН КМТУС
ДЕБЮТ ТЕАТРТ

<https://x.com/PLinMongolia/>

Plakat Dni Polskiego Kina w Mongolii. Polskie filmy przyciągają rzesze mongolskich widzów.
Монголд зохион байгуулагддаг Польшийн кино өдрүүдийн сурталчилгааны зурагт хуудас.
Монголд польш кино сонирхогчид нэмэгдсээр байна.



Podobnym uznaniem cieszą się konkursy i koncerty chopinowskie organizowane co roku w Mongolii.
Монголд уламжлал болгон жил бүр зохион байгуулагддаг Ф. Шопены нэрэмжит төгөлдөр хуурчдын уралдаан, тогололтууд монголчуудын дунд нэр хүндтэй арга хэмжээний нэгд тооцогддог.

Монголын түүх, соёл урлагийн өвийг сурталчлан таниулах гол байгууллага Варшав дахь Ази Номхон далайн музей, Буда Руска дахь Монгол музей юм. Ази Номхон далайн музей "Дорно зүгт аялах" нэртэй байнгын үзэсгэлэнгийн хүрээнд Монголын түүх, соёлын өвд зориулсан тусгай танхимтай. Харин Буда Руска бол бүхэлдээ Монголын соёл урлагийн өвийг үзүүлсэн үзэсгэлэнтэй юм.

Польшийн соёл урлагийг Монголд өндрөөр үнэлж, түгээн дэлгэрүүлж байна. Тухайлбал: Ф.Шопены нэрэмжит Олон улсын төгөлдөр хуурчдын уралдаан, Польшийн кино өдрүүд зэрэг арга хэмжээнүүд Улаанбаатар хотод зохион байгуулагддаг. 13 дахь удаагийн Польшийн кино өдрүүд 2024 онд болж, "Хүндэтгэсэн Винсент", "Сүм" зэрэг кинонуудыг толилуулж байв.

POLSKA I MONGOLIA W FILATELISTYCE

I NUMIZMATYCE

ПОЛЬША БА МОНГОЛЫН ТУХАЙ ШУУДАНГИЙН МАРК БА ЗООС

W czasach socjalizmu kolekcjonowanie było popularnym hobby. Słynne znaczki pocztowe krajów socjalistycznych cieszyły się dużym zainteresowaniem wśród pasjonatów, zarówno początkujących, jak i doświadczonych kolekcjonerów. W okresie socjalizmu Mongolski Departament Łączności Państwowej po raz pierwszy wydał trzy serie portretów Mikołaja Kopernika, jeden blok 20 marca 1973 r., aby uczcić 500. rocznicę urodzin słynnego polskiego naukowca i astronoma Mikołaja Kopernika (1473-1543).

W 1980 roku Poczta Polska wydała serię zatytułowaną „Polska Ekspedycja Naukowa”. Dwa z sześciu znaczków serii poświęcone były wspólnym badaniom mongolsko-polskim, upamiętniającym wspólne badania antropologiczne i paleontologiczne prowadzone w Mongolii w latach 60. i 70. XX wieku.

Po 1990. roku Mongolska Poczta wydała serię znaczków o tematyce związanej z postaciami wielkich Polaków, a w 1992 roku wydano dwa znaczki okolicznościowe ze złotą i srebrną ramką przedstawiające głowę Kościoła katolickiego, Jana Pawła II. W 1993 roku na Międzynarodową Wystawę Znaczków „POLSKA '93” w Poznaniu wydano trzy bloki z wizerunkami Mikołaja Kopernika, Jana Pawła II i Fryderyka Chopina, a także serię bloków łączących te trzy postacie.



Социализмын үед ямар нэг цуглуулга хийх нь түгээмэл хобби байлаа. Социалист орны шуудангийн марк нь сонирхогч, анхлан болон туршлагатай цуглуулагчийн аль алиных нь сонирхолыг ихээр татдаг байв. Монгол Улсын харилцаа холбооны газраас 1973 оны 3 сарын 20-нд Польшийн алдарт эрдэмтэн одон орон судлаач Николай Коперникийн (1473-1543) мэндэлсний 500 жилийн ойд зориулан түүний хөрөг, лаборатори гурван сери, нэг блок маркийн цуврал, өдрийн дугтуйн хамт гаргасан байна.

1980 онд Польшийн шуудан "Польшийн шинжлэх ухааны экспедиц" нэртэй цуврал зургаан марк гаргахдаа хоёрыг нь 1960-1970-аад онд хийсэн Польш, Монголын хамтарсан антрополог, палеонтологийн судалгаанд зориулжээ.

Монгол шуудан компани 1990 оноос хойш Польшийн дэлхийд алдартай хэд хэдэн хүний сэдвээр маркийн цуврал гаргажээ. 1992 онд Католик шашны тэргүүн II Иохан Паулын дүртэй хүндэтгэлийн алт, мөнгөн хүрээтэй 2 блок марк гаргажээ.

1993 онд Польш Улсын Познань хотод зохион байгуулагдсан "POLSKA '93" Олон улсын шуудангийн маркны үзэсгэлэнд зориулан Николай Коперник, II Иохан Паул, Фридерик Шопены дүртэй 3 блок, гурван хүнийг нэгтгэсэн нэг хэлхээ блок марк гарсан байна.



W 2008 roku Centralny Bank Mongolii wyemitował złote i srebrne monety o nominale 1000 i 500 tugrików ku pamięci Fryderyka Chopina, jako część serii monet pamiątkowych.



Монгол Улсын Төв банкны олон цуврал дурсгалын зоосон дотор Фридерик Шопены ойд зориулан 2008 онд гаргасан 500 болон 1000 төгрөгийн алтан, мөнгөн зоос байна.

Kuratorzy wystawy:

Anna Brzezińska

Kamil Krajnik

Jan Rogala

Үзэсгэлэнгийн кураторууд:

Анна Бжезиньска

Камил Крайник

Ян Рогала

Teksty w języku polskim:

Anna Brzezińska

Kamil Krajnik

Jan Rogala

Польш хэлний үг:

Анна Бжезиньска

Камил Крайник

Ян Рогала

Redakcja i korekta tekstów polskich:

Anna Brzezińska

Jan Rogala

Польш хэлний редакц:

Анна Бжезиньска

Ян Рогала

Tłumaczenie na język mongolski:

Jan Rogala

Монгол хэл рүү орчуулга:

Ян Рогала

Redakcja i korekta tekstów mongolskich:

Рагчаагийн Бямбаа

Монгол хэлний редакц:

Рагчаагийн Бямбаа

Patronat: / Ивээл дор:

